



**БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Компанийн зохион байгуулалтын бүтэц, Г
орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн а/578 дугаартай удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцийг хавсралтад заасны дагуу шинэчлэн баталсугай.

2. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан орон тооны дээд хязгаарыг 550 байхаар тогтоосугай.

3. Батлагдсан бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан ажил, мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, мөрдүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Ганчулуун)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Д.Гэрэл), Цалин урамшууллын хороо (Ц.Түвшинзаяа)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Г.ЭНХТҮВШИН

"БЗӨБЦТС" ТӨХК-ийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн 20-⁰⁸ оны 03 дугаар
сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолын
... дүгээр хавсралт



“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

